


Л.ГАНТӨМӨР



Б.ЖАВХЛАН



О.АЛТАНГЭРЭЛ

**“МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ”
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад “Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна.” гэж, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт “Засгийн газар Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 05 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. Улсын Их Хурал 06 дугаар сарын 01-ний дотор батална.” гэж тус тус заасны дагуу “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулна.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй уялдуулан, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.1 дэх заалтад “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл,...Засгийн газрын...үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулсан байх;” гэж, 6.10.2 дахь заалтад “санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон, хариуцах эзэнтэй, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан, тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг эрэмбэлсэн байх; гэж заасан шаардлагад нийцүүлнэ.

Хоёр.Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Тогтоолын төсөл нь 4 заалт, 3 хавсралттай байх бөгөөд нэгдүгээр заалтад Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийг нэгдүгээр хавсралтаар, Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар, Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтүүдийг гуравдугаар хавсралтаар батлах тухай, хоёрдугаар заалтад Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөг баталсантай холбогдуулан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгах тухай, хоёрдугаар заалтын нэгд

Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд туссан улсын төсвийн эх үүсвэрээр санхүүжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгах тухай, хоёрдугаар заалтын хоёрт Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд төр, хувийн хэвшлийн түншлэл болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр тусгасан төсөл, арга хэмжээнд шаардагдах бэлтгэл ажлыг хангаж ажиллах тухай, хоёрдугаар заалтын гуравт Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн зохион байгуулж, биелэлтийг жилээр нэгтгэн гаргаж, Улсын Их Хуралд танилцуулах тухай, гуравдугаар заалтад энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд даалгах тухай, дөрөвдүгээр заалтад тогтоолыг дагаж мөрдөх хугацааны тухай тус тус тусгана.

Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгагдсан зорилго, зорилттой уялдсан “Эдийн засгийн эрх чөлөөг цогцлоох” зорилгын хүрээнд “Бүсчилсэн хөгжлийн бодлого”, “Хүний хөгжлийн бодлого”, “Эдийн засгийн бодлого”, “Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” гэсэн 4 бодлогын тэргүүлэх чиглэлтэй бөгөөд эдгээрийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагч, хөтөлбөрийн үр дүн болон төсөл, арга хэмжээ, түүний бодлогын үндэслэл, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшин, шаардлагатай хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр, үндсэн хариуцах байгууллагыг тусгана.

Гурав.Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Тогтоолын төсөл батлагдсанаар инфляцыг зорилтот түвшинд хадгалах мөчлөг сөрсөн төсвийн бодлогыг хэрэгжүүлж, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж, ядуурлыг бууруулж, ажлын байрыг нэмэгдүүлж, хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогыг хэрэгжүүлнэ.

Дөрөв.Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Хууль тогтоомжийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжтой нийцсэн бөгөөд тогтоолын төсөлтэй холбогдуулан нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тогтоомж байхгүй болно.